

# Төслийн товчоон

ШВЕЙЦАРИЙН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГ



Schweizerische Eidgenossenschaft  
Confédération suisse  
Confederazione Svizzera  
Confederaziun svizra

2017 оны 5-р сар

Хэрэгжүүлэгч:



Swiss Agency for Development  
and Cooperation SDC  
Швейцарийн хөгжлийн агентлаг

## ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТӨСӨЛ

### БАРИМТ МЭДЭЭЛЭЛ

#### Төслийн нэр:

Монгол улсын хүрээнд жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төсөл

#### Хугацаа:

2016-2020

#### Төсөв:

ШХА: 4,3 сая ам.доллар  
НҮБХАС: 853,000 ам.доллар  
Засгийн газар: 452,000 ам.доллар

#### Зорилтот бүлэг:

- ЖСХ-ийн хохирогчид, хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй хүмүүс
- Хүчирхийлэл үйлдэгчид, хүчирхийлэл үйлдэх эрсдэлтэй хүмүүс
- Бодлого шийдвэр гаргагчид
- Монголын нийт ард иргэд

#### Зорилтот бүс нутаг:

Үндэсний хэмжээнд



Залуус эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эсрэг нэгдлээ. © НҮБХАС

### ОРШИЛ

Өнгөрсөн хорь гаруй жилийн хугацаанд болж өрнөсөн Монгол улсын улс төр, эдийн засгийн шилжилт нийгэм соёлын хэмжээнд ихээхэн нөлөөлсөн. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны 2015 оны үнэлгээгээр Жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ), ялангуяа гэр бүлийн хүчирхийлэл нь Монгол улсын хувьд түгээмэл, өргөн тархалттай байгааг онцолсон. ГБХ-тэй тэмцэх хууль батлагдаж, хохирогч хамгааллын болон салбар хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх хүрээнд ахиц ололтууд гарч байгаа хэдий ч ЖСХ нь хүний эрх, эрх чөлөө, амь насанд

нь заналхийлсэн хүний эрхийн ноцтой зөрчлийн нэг байсаар байна. Тиймээс ЖСХ-тэй тэмцэх төсөл нь шаардлагатай мэдээллийг цуглуулж, хүчирхийллийн шалтгаан, нөхцлийн талаарх нотолгоо мэдээллийг бий болгох, олон нийтийн болон бодлого боловсруулагчдын ойлголт мэдлэг, ухамсар, дэмжих хандлагыг нэмэгдүүлэх, хохирогч хамгааллын механизмыг бий болгон, салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар ЖСХ, ялангуяа ГБХ-тэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үндэсний чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх юм.

### ТӨСЛИЙН ЗОРИЛТ:

Монгол улсад жендэрт суурилсан хүчирхийлэл, ялангуяа гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, ирээдүйд бүрэн устгах үндэсний чадавхыг дээшлүүлэх зорилготой.

### ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төслийн хүрээнд дараах гурван чиглэлийн үйл ажиллагааг явуулна.

- Улс орон даяар ЖСХ/ГБХ, түүний суурь шалтгааныг тодруулах мэдээлэл цуглуулах,
- Олон нийт, ард иргэд, шийдвэр гаргагчдын ЖСХ/ГБХ-ийн талаар мэдлэг

мэдээллийг дээшлүүлэх, уг асуудалд илүү мэдрэмжтэй хандах хандлагыг дэмжих;

- ЖСХ/ГБХ-ийн хохирогч хамгааллын тогтолцоо болон салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэн сайжруулах

## ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮН

1. ЖСХ/ГБХ-ийн асуудлаар хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай үндэсний хэмжээний нотолгоо мэдээлэлтэй болсон байна. Энэхүү үр дүнд хүрэхийн тулд:

- ЖСХ-ийн судалгааг орон даяар зохион байгуулах,
- Цагдаагийн ерөнхий газрын ЖСХ-ийн мэдээллийн санг сайжруулах ажлуудыг хийх юм.

2. ЖСХ/ГБХ-ийн талаархи олон нийт болон шийдвэр гаргагчдын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж, ЖСХ/ГБХ-ийг таслан зогсоох үйл ажиллагааг эрчимжүүлэх. Энэхүү үр дүнд хүрэхийн тулд:

- ЖСХ/ГБХ-ийн асуудлыг дунд болон мэргэжлийн боловсролын сургалтын хөтөлбөрт оруулна.
- ЖСХ-ийн асуудлыг холбогдох их сургуулийн хөтөлбөрт оруулж, эрүүл мэнд, нийгэм, цагдаа зэрэг салбарын үйлчилгээ үзүүлэгчдийг сургана.
- Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, хөвгүүд, охидууд, өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ЛГБТ хүмүүст зориулсан ЖСХ/ГБХ сэдвээр олныг хамарсан мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх кампанит ажлуудыг дэмжинэ.
- Хэвлэл мэдээллийн сувгуудаар дамжуулан олон нийтэд ЖСХ/ГБХ-ээс урьдчилан сэргийлэх талаар мэдлэг мэдээлэл хүргэнэ.
- ГБХ-тэй тэмцэх тухай хууль болон бусад холбогдох хуулиудыг батлуулах, хэрэгжүүлэх, ухуулга нөлөөллийн ажилд дэмжлэг үзүүлнэ.
- Хүний эрхийн төлөв байдлын илтгэл, бусад олон улсын гэрээ конвенцуудын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд Засгийн газарт дэмжлэг үзүүлнэ.

3. ЖСХ/ГБХ-ээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үйл ажиллагааг дэмжсэн орчинг бий болгох. Энэхүү үр дүнд хүрэхийн тулд:

- Хохирогчдыг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлж байгаа Нэг цэгийн үйлчилгээний төвүүд (НЦҮТ) болон Хамгаалах байруудын чадавхыг бэхжүүлнэ.
- Судалгааны дүнд үндэслэн шинээр НЦҮТ болон хамгаалах байр байгуулахад дэмжлэг үзүүлэх, нөлөөллийн ажлууд хийнэ.
- Шинээр байгуулагдсан НЦҮТ болон хамгаалах байруудад шаардлагатай аргагүй, санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

- Одоо үйл ажиллагаа явуулж байгаа болон шинээр байгуулагдах НЦҮТ болон хамгаалах байруудыг институтчилэх, тэдгээрийн үйл ажиллагаанд хангалттай санхүүжилт хуваарилуулах нөлөөллийн ажилд дэмжлэг үзүүлнэ.
- Үйлчилгээ үзүүлэгчдийн чадавхыг бэхжүүлнэ.

## ХҮРСЭН ҮР ДҮНГҮҮД

(2016 оны 4 дүгээр улирлын байдлаар)

Орон даяар хийгдэх ЖСХ-ийн тархалтын судалгааны түүврийн хэмжээ, төлөвлөгөөг багтаасан судалгааны үзэл баримтлалыг боловсрууллаа. Үндэсний статистикийн хороон дээр судалгааны баг болон зөвлөлдөх хороо байгуулагдсан. Мөн, ЖСХ/ГБХ-ийн нэгдсэн мэдээллийн сангийн хэрэгцээг тодорхойлох үнэлгээг хийж, үр дүнг Цагдаагийн ерөнхий газар болон бусад холбогдох талуудад танилцуулан зөвшилцөв.

Нөлөөллийн кампанит ажлуудыг өргөн хүрээнд зохион байгуулж, олон нийтийн зүгээс шийдвэр гаргагчдад шахалт үзүүлсний үр дүнд 2016 оны 12 сарын 22-ны өдөр Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль батлагдсан.

Олон нийтийн ЖСХ-ийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхийн тулд сэтгүүлчдийн зүгээс зөв, мэдрэмжтэй мэдээлэл хүргэх чадавхыг бэхжүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар 2016 онд Хэвлэлийн хүрээлэнтэй хамтран ажиллах гэрээ байгуулсан.

ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, түүний эсрэг хариу арга хэмжээ авах сэдвээр Хуулийн хүрээлэнгийн Хууль зүйн төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрт оруулсан. Хууль сахиулах их сургууль дээр анхны сургалтууд эхлээд явж байна.

Иймд, Онцгой байдлын ерөнхий газартай гамшиг ослын үед охид эмэгтэйчүүдийн онцлог хэрэгцээ шаардлагад үр дүнтэй, бодитойгоор тусламж хүргэх чиглэлд хамтран ажиллаж эхэлсэн.



Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг олон талт хамтын ажиллагаа сэдэвт форум.

## Хамтран хэрэгжүүлэгч түншүүд:

- Хууль зүй, дотоод хэргийн яам
- Эрүүл мэндийн яам
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам/Жендэрийн тэгш эрхийн үндэсний хороо
- Цагдаагийн ерөнхий газар
- Үндэсний статистикийн хороо

## Холбоо барих:

### НҮБ-ын Хүн амын сан

НҮБ-ын байр, Нэгдсэн үндэстний гудамж 14, Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Улаанбаатар 14201 Монгол улс

+976 11 353501, 353503  
353504, 353505

+976 11 353502

contact@unfpa.org.mn

www.mongolia.unfpa.org

## Швейцарийн ЭСЯ-ны Хамтын ажиллагааны газар

Монгол Улс, Улаанбаатар хот Элчингийн гудамж, 1-р хороо Скай Плаза Бизнес төв Ш/Х 37, Улаанбаатар 14210

+976 11 331422

+976 11 331420

ulaanbaatar@eda.admin.ch

www.swiss-cooperation.admin.ch/mongolia

Swiss Cooperation in Mongolia